



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДЭД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд тусгасан Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журам, шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болох зохицуулалтыг уг хуульд нийцүүлэн зохицуулах шаардлага үүсээд байгаа билээ. Энэ хүрээнд:

✎ Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хурлаас 2012 онд батлан хэрэгжүүлж байгаа Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нэгтгэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,

✎ Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын шүүхийн тухай, Шүүгчийн эрх зүйн байдал, сахилга, хариуцлагын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн гэрээт дэд профессор, хууль зүйн доктор Ц.Цогтын хуулийн төслүүдэд өгөх саналыг Та бүхэнд танилцуулж байна.

① Шүүхийн ерөнхий зөвлөлийн “шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан” байдлыг хангах, хамгаалахтай холбоотой чиг үүргийг¹ “нарийвчлан тодорхойлж” хуульчлах тухайд:

» Шүүхийн ерөнхий зөвлөл нь **орон тооны байгууллага** байж Шүүгчийн хараат бус байдал, Шүүхийн бие даасан байдалд халдсан тохиолдлыг шийдвэрлэх, хамгаалах боломжтой:

✎ Ажлын алба нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэшил чадвар, бүрэн эрх бүхий нэгжээс бүрдэх ёстой. Үүнд, нэн түрүүнд шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүтцийн нэгж заавал ажиллах талаар хуульчилж өгөх;

✎ Шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүгчийн хараат бус байдлыг хангах газартай байхыг заах;

✎ Энэхүү чиг үүргээ хэрхэн ямар арга замаар хэрэгжүүлэхийг тодорхой заах, үүнтэй холбоотой бүрэн эрхийг хуульчлах.

¹Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2 дугаар тогтоолын хавсралтын 3.1-д “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүргийг тодорхойлох;”

- » Шүүхийн ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчийг шилж сонгох эрхийн тухайд:
 - ✍ Томилгоонд санал өгөх эрх нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн дур зоргод үлдээсэн зүйл биш, Үндсэн хуулийн зарчмаар Шүүхийн ерөнхий зөвлөл нэр дэвшин өрсөлдөж буй хүмүүсээс тухайн албан тушаалд хэн нь ёс зүй, мэргэжлийн ур чадвар, туршлагаараа хамгийн илүүг нь сонгох учиртай (*ядаж интервал тогтоох, хамгийн өндөр оноотой 3-аас сонгох гэх мэт*);
 - ✍ Эсвэл Шүүхийн мэргэшлийн хороо сул орон тоонд 3 нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлд санал болгох, Шүүхийн ерөнхий зөвлөл уг жагсаалтаас сонгох эрхтэй байхаар зохицуулах;
 - ✍ Шүүхийн ерөнхий зөвлөл өрсөлдөгчдөөс тодорхой нэр дэвшигчийг сонгох болсон үндэслэлээ шийдвэртээ тайлбарлах үүрэгтэй байх (ингэснээр дарамт шахалт, дур зорго хязгаарлагдана);
 - ✍ Шийдвэрийн үндэслэл тодорхойгүй, Шүүхийн мэргэшлийн хорооны болон бусад үнэлгээ, дүгнэлтээс илтэд зөрүүтэй тохиолдолд уг шийдвэрийг нэр дэвшигч хянуулах эрхтэй байх.

② Хяналтын шатны шүүхийн чиг үүрэг болоод хууль тайлбарлах эрхийн тухайд:

- » Дээд шатны шүүхүүд процессын болон материаллаг хуулиудын шүүхийн хэрэглээнд суурилсан жишиг, практик тогтоох эрхтэй байх зохицуулалт нэвтрүүлэх.
- » Шүүх (бүрэлдэхүүн) тодорхой хэргийг шийдвэрлэх явцдаа хэрэглэгдэх хуульд “тайлбар” шаардлагатай гэж үзвэл хэргээ түдгэлзүүлээд саналаа Улсын дээд шүүхийн Танхимд хүргүүлнэ, танхим (*эсхүл танхим өөрөө хэрэг шийдэх явцдаа*) хэлэлцээд зөвшөөрвөл нийт шүүгчдийн хуралдаанд саналаа оруулж, уг хэрэг дээр суурилан хэрэглээний тайлбар гаргадаг байх;
- » Улсын дээд шүүх хэрэг хүлээн авч хэлэлцэх хязгаар, зарчмыг Шүүхийн тухай хуульд зааж өгч улмаар процессын хуулиудаар тодруулан зохицуулах боломжийг бүрдүүлэх, Тухайлбал, Улсын дээд шүүх дараах үндэслэлүүдээр хэрэг хянах хязгаартай байх:
 - ✍ Доод шатны шүүхүүд хууль хэрэглээний зөрүүтэй;
 - ✍ Практик тогтоох ач холбогдолтой;
 - ✍ Шинэ хууль, ойлголтын эхний хэрэглээ;
 - ✍ Доод шатны шүүх бүрэлдэхүүний тусгай саналтай;
 - ✍ Доод шатны шүүхүүдийн шийдвэрт хүний эрхийн ноцтой зөрчил гарсан байж болзошгүй гэх мэт.

---ooOoo---

- » Улстөрийн хараат бус байдлыг хангах хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан байдал болон шүүгчийн хараат бус байдал хэрхэн хангах арга замыг тодорхой зааж өгөхгүйгээр энэ баталгаа бодит байдал дээр хэрэгжихгүй (өмнөх 30-аад жилийн туршилагаас хэрэгжиж байгаагүй нь тодорхой байгаа) учир:
 - ✍ Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх (болон Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл гэх мэт байгууллага өөр өөрийн шийдвэр, үйл ажиллагаагаар) замаар шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халдсан, уг үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцыг эхлүүлсэн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл энэ асуудлаар Үндсэн хуулийн §64.1, §66.1, §66.2.1, §66.2.3-т заасны дагуу Улсын дээд шүүхээр дамжуулан Үндсэн хуулийн цэцэд хандах, Цэц шууд маргаан үүсгэх, улмаар шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдалд халдсан, уг үйл ажиллагаа, шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлдэг байхаар зааж өгөх;
 - ✍ Гүйцэтгэх эрх мэдлээс шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдалд нөлөөлөх, хамааралтай аливаа асуудал шийдвэрлэх үед Шүүхийн ерөнхий зөвлөлийн оролцоог хангахыг үүрэгжүүлсэн зохицуулалт оруулах;
 - ✍ Шүүхийн бие даасан байдал болон шүүгчийн хараат бус байдлыг Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны уялдааг Үндсэн хуулийн §66.1 болон Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан §49.5 дахь зохицуулалтын дагуу нарийвчлан зохицуулах;
 - ✍ Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой тайланг танилцуулах хэлбэр, хугацаа, тохиолдол бүрийг тодорхой заах;
 - ✍ Тайланг танилцуулсантай холбоотой хийгдэх ажил үүрэг, үр дагварыг зохицуулах
- » Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулах зохицуулалтыг нарийвчлан хуульчлах:
 - ✍ Энэ чиг үүргээ удаа дараа хэрэгжүүлэхгүй, зайлсхийсэн, эсхүл бүр энэ чиг үүргээ зөрчиж шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халдсан шийдвэр гаргасан, оролцсон тохиолдолд эгүүлэн татах процесс эхлүүлэх зохицуулалтыг оруулах (2013 оны 12-р сарын 18 –ны өдрийн тохиолдол шиг үед хэрэглэх);
 - ✍ Нөлөөллийн мэдүүлгийн зохицуулалттай холбоотой одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хариуцлагын зохицуулалтыг хэвээр хадгалах;
 - ✍ Шүүгчдийн зөвлөлөөр Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн сахилгын хорооны гишүүнийг сонгохтой холбогдуулан шүүгч нарт болон шүүгч нар өөр хоорондоо аль нэг нэр дэвшигчийг дэмжих, дэмжихгүй байх талаар ил далд зохион байгуулалттай ажил явуулахыг хориглож, хэрхэн санал өгөх талаар нөлөөлөхийг хориглох, зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авах үндэслэл болох заалт оруулах;
 - ✍ Тусгай саналыг анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэртэй хамт нийтлэгдэг болгох;

- ✍ Шүүгчийн томилгоо, сонгон шалгаруулалтад оролцоотой эрх бүхий субъектүүд (*Шүүхийн мэргэшлийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхийлөгчийн институт зэрэг*) –тэй ашиг сонирхлын үүднээс харилцаа тогтоох, аливаа нөлөөлөл хийхийг (*гуйх гувших, зуучлуулах, улстөрчидтэй холбоо сүлбээ тогтоох, дэмжлэг хүсэх гэх мэтээр*) нэр дэвшигч нарт болон тэдний өмнөөс эдгээр үйлдлийг хийж буй өөр этгээдүүдэд хориглох, шүүгч үүнийг зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авах үндэслэл болох заалт оруулах, өөр бусад этгээдийн ийм зөрчилд “нөлөөллийн мэдүүлэг”-тэй холбоотой зохицуулалт, хариуцлага үйлчлэхээр заах;
 - ✍ Хэрэг хуваарилах, бүрэлдэхүүн томилох журмын “хэрэгжилтийг” ил тод болгох зохицуулалт;
 - ✍ Татгалзан гарах, ашиг сонирхлын нэгдэл, зөрчлийн улмаас тухайн шүүгчийн итгэл үнэмшлийг хүндэтгэх (*шүүгч өөрөө татгалзан гарах эрхийг хангах*) замаар шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлэх зохицуулалт хийх;
 - ✍ Шүүхийн мэргэшлийн хорооны “assessment”-ийн дагуу шүүгчийг албан тушаалаас чөлөөлөх нь нэг тохиолдолд суурилах биш тухайн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшин зэргийг бүрэн илэрхийлэх тодорхой хугацаа, давтамжтайгаар хийгдэх, улмаар удаа дараагийн дүгнэлт нь мэргэжлийн хувьд шаардлага хангахгүй болсныг тогтоох үндэслэл болдог байхаар зохицуулах.
- » Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах, хамгаалахтай холбоотой гарсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрт гишүүний өгсөн санал ил байх (*чиг үүргээ хэрэгжүүлэхээс зайлсхийх, эсхүл Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдалд халдсан шийдвэр гаргасан, гаргахад оролцсон зэрэг нь ил тод байж гэмээ нь хариуцлага хүлээх боломж бүрдэнэ*).
 - » Шүүхийн ерөнхий зөвлөлийн таван шүүгч-гишүүдийг шат шатны шүүхийн төлөөлөл байх хувийг (*анхан шат-2, давах шат-2, хяналтын шат-1 гэх мэтээр*) хуульд тодорхой зааж өгөх (*Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын дагуу*). Ингэснээр нэр дэвших, санал өгөх үйл ажиллагааг нээлттэй, тодорхой болгох, төлөөллийг бүрэн хангах нөхцөл бүрдэнэ.
 - » Шүүгчдийн зөвлөлийг шүүхүүдээс төлөөллийн журмаар бүрдүүлэх биш, шүүгч бүр санал өгч оролцох эрхтэй байхаар зохицуулах, ингэсээр шүүхийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шүүгч бүрийн оролцоог хангах, дотоод хараат бус байдал алдагдах, төлөөлөгч нэрээр санал багцлах, хуурамч-төлөөллийн дүнд эрх мэдэл төвлөрөх, төлөөлүүлсэн эрх мэдлийг урвуулан ашиглах зэргээр хуучны алдааг давтахгүй байх.
 - » Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчдээс бусад таван гишүүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, түүнийг хэрэгжүүлэх тухай Улсын Их Хурлын 2020 оны 2-р тогтоолд нийцүүлж, төрийн болон нийгмийн бусад олон талт институтүүдын түүний дотор хууль зүйн болон хүний эрхийн чиглэлийн мэргэжлийн, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн тэнцвэртэй оролцоог хангасан байдлаар бүрдүүлэхээр зохицуулах.